



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2011 оны 08 сарын 16 өдөр

Дугаар

17/335 -

Мандалговь

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг
сунгах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэдалай сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг "Надаши" ХХК-ний XV-48000081(033/Ду), Дэлгэрхангай сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг "Идэрговь транс" ХХК-ний XV-48000067(004/Ду) дугаартай тусгай зөвшөөрлүүдийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрдэнэдалай сумын Засаг дарга (Б.Лхагвамандал) Дэлгэрхангай сумын Засаг дарга (М.Батсүх) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг захирал (Д.Доржбат, В.Насанбат) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111145